



УЛААНБААТАР ХОТЫН ШУУРХАЙ УДИРДЛАГА,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ТӨВ ОНӨААТҮГ  
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 03 сарын 22 өдөр

Дугаар А/07

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 145 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын Шуурхай удирдлага, зохицуулалтын төв” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дүрмийн 4.9.9, Хөдөлмөрийн дотоод журмын 3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улаанбаатар хотын Шуурхай удирдлага, зохицуулалтын төв” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын статусыг хэвээр хадгалах эсвэл төсөвт үйлдвэрийн газар болох үндэслэлийг боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга :	Н.Батсүх	Дотоод хяналт, хамтын ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн
Гишүүд:	Б.Дамдинжав Б.Оюунжаргал П.Батбилэг Б.Энхсайхан Э.Мэндбаатар Г.Билгүүн Л.Сугаррагчаа	Ерөнхий диспетчер Ахлах нягтлан бодогч Системийн ахлах инженер Програм хангамжийн инженер Сүлжээний инженер Техник хангамжийн инженер Ахлах диспетчер-инженер
Нарийн бичгийн дарга:	Б.Биндэръяа	Даргын туслах, архив, бичиг хэргийн ажилтан

2. Ажлын хэсгийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Ажлын хэсгийн дарга /Н.Батсүх/-д даалгасугай.

ДАРГА Ч.ТАН-ОЧИР

